



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
АРВАЙХЭЭР СУМЫН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2024 оны 12 сарын 17 өдөр

Дугаар 2/02

Арвайхээр сум

Арвайхээр сумын Засаг даргын
2024-2028 оны үйл ажиллагааны
хөтөлбөрийг батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.1 дэх, 35 дугаар зүйлийн 35.1.5 дахь, Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.11.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Арвайхээр сумын Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг 4 бүлэг, 53 зорилт, 172 үйл ажиллагааг баталсугай.

2. Арвайхээр сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг үнэлэх хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлтийг 2025 оны нэгдүгээр улиралд багтаан сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хуралдаанаар хэлэлцүүлэх, мөн хугацаанд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг баталж, аймаг, сумын хөгжлийн жил бүрийн төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлж, тайлагнан ажиллахыг сумын Засаг дарга бөгөөд хотын Захирагч (Б.Ганбат)-д даалгасугай.

3. Хөтөлбөрийн зорилго, зорилтуудыг хэрэгжүүлж, Арвайхээр хотоо хөгжүүлэхэд идэвх, санаачилга гарган ажиллахыг Арвайхээр сумын нийт иргэд, аж ахуйн нэгж, төрийн болон төрийн бус байгууллагад уриалсугай.

ДАРГА

Ц.ТӨМӨРБААТАР

622401018

Арвайхээр сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2024 оны 18 дугаар сарын 17-ны өдрийн
2/02 дугаар тогтоолын хавсралт



АРВАЙХЭЭР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН 2024-2028 ОНЫ
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨР

НЭГ. БҮСЧИЛСЭН ХӨГЖЛИЙН БОДЛОГО

1.1. УЛСЫН БҮСЧЛЭЛ-ХАНГАЙН БҮС

Уламжлалт мал аж ахуйн төрөлжсөн бүс бөгөөд хот байгуулалтын дэд бүс болно.

1.1.1. Хөдөө аж ахуй, хүнсний үйлдвэрлэл, үйлчилгээ, худалдаа, бирж, тээвэр логистикийн цогцолборыг кластераар хөгжүүлэх хувийн хэвшил, хоршоодыг тэргүүн ээлжид дэмжинэ.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

1.1.1.1. Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлэх томоохон мега төслүүдийг хэрэгжүүлэхэд орон нутгийн зүгээс ажиллах хүч, техник хэрэгсэл, шаардлагатай бараа материалыг нийлүүлэх замаар эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлнэ.

1.1.2. Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлэх томоохон мега төслүүдийг хэрэгжүүлэхэд орон нутгийн зүгээс ажиллах хүч, техник хэрэгсэл, шаардлагатай бараа материалыг нийлүүлэх замаар эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлнэ.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

1.1.2.1. Орхон-Онги төслийн бүтээн байгуулалтад ажиллах хүч, шаардлагатай хүнс, өргөн хэрэглээний бараа материалыг нийлүүлэх замаар шаардлагатай дэмжлэг үзүүлж ажиллана.

1.1.2.2. Түүх, соёлын аяллыг хөгжүүлж, археологийн нөөцөд тулгуурласан соёлын болон танин мэдэхүйн аялал жуулчлалыг хөгжүүлэхэд төр хувийн хэвшлийн байгууллагуудтай хамтран ажиллана.

1.2. ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН ДЭД ТӨВ

Орон нутгийн хөгжлийн төв, тэдгээрт таталцах сум, сууринг хөгжүүлэх бодлогыг хэрэгжүүлнэ.

1.2.1. Орон нутгийн хөгжлийн төв Арвайхээр хотыг “Төвийн бүс”-ийн тээвэр логистик, хөнгөн үйлдвэрлэлийн чиглэлээр хөгжүүлнэ.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

1.2.1.1. “Хангайн бүс”-ийн бүтээн байгуулалтын хэрэгцээг хангах барилгын материалын хангамж, үйлдвэрлэл үйлчилгээ, тээвэр логистикийн төвийг байгуулахад хамтран ажиллаж, дэмжлэг үзүүлнэ.

1.2.1.2. Арвайхээр хотод үйл ажиллагаа явуулж байгаа мах, сүү, ноос, арьс, шир боловсруулах чиглэлийн үйлдвэр, хоршоог үйлдвэрлэлээ савхи, савхин эдлэл үйлдвэрлэх, ноос ээрэх, ноолуур угаах, самнах чиглэлээр өргөтгөх санал санаачилгыг дэмжин ажиллана.

1.2.1.3. Таталцах сумдад хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг үйлдвэрийн аргаар боловсруулж, орон нутгийн хөгжлийн төвийн иргэдийн хэрэгцээний ханган нийлүүлэлтэд бодлогоор дэмжин хамтын ажиллагааг өргөжүүлнэ.

1.2.1.4. Малын тэжээл тариалах, мах сүүний эрчимжсэн аж ахуй, малын гаралтай түүхий эд бэлтгэх, анхан шатны боловсруулалт хийх аж ахуйг дэмжинэ.

ХОЁР. ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО

2.1.ТЭГШ ХҮРТЭЭМЖТЭЙ, ЧАНАРТАЙ БОЛОВСРОЛ

Хүүхэд бүрд чанартай боловсрол эзэмших тэгш боломжийг бүрдүүлж, сургалтын чанарыг дээшлүүлэн, соёл, уламжлал, үнэт зүйлсийг өвлөсөн, хүмүүнлэг, ёс зүйтэй, өв тэгш иргэнийг төлөвшүүлнэ.

2.1.1.Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, Политехник коллежийн сурагчдын сурлагын амжилт, гүйцэтгэлийн үнэлгээний үр дүнг дээшлүүлнэ.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

2.1.1.1.Анги нийтийн аймгийн олимпиадад анги хамт олныг бэлтгэн оролцуулах, амжилтыг ахиулах, үнэлэх бодлого хэрэгжүүлнэ.

2.1.1.2.Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгүүдэд зөвлөн туслах үйл ажиллагааг зохион байгуулж, багш, сурагч солилцооны хөтөлбөрийг бүсийн болон бусад бүсийн сургууль, цэцэрлэгтэй хамтран зохион байгуулж, шилдэг арга зүй, тэргүүн туршлагыг түгээн дэлгэрүүлнэ.

2.1.1.3.Намхайн Төмөрхүү агсаны нэрэмжит Физикийн улсын олимпиадыг уламжлал болгон жил бүр зохион байгуулна.

2.1.2.Боловсролын байгууллагын барилга, байгууламж, дэд бүтцийг сайжруулан, стандарт, чанарын шаардлага хангасан, тэгш хүртээмжтэй, чанартай үйлчилгээ үзүүлэх орчныг бүрдүүлж, цэцэрлэг, сургуулийн анги, бүлэг дүүргэлтийг багасгана.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

2.1.2.1. 11 дүгээр (тусгай) цэцэрлэгийн хүүхдүүдийн сурч хөгжих орчныг сайжруулахад дэмжлэг үзүүлнэ.

2.1.2.2.Шинээр ашиглалтад орж байгаа болон ашиглагдаж байгаа ерөнхий боловсролын сургууль, сургуулийн өмнөх боловсролын байгууллагын барилгын гадна болон дотор орчны хүртээмжийн үнэлгээ хийж, хүртээмжийг нэмэгдүүлнэ.

2.1.2.3. Ерөнхий боловсролын сургууль, сургуулийн өмнөх боловсролын байгууллагуудын гадна тоглоомын талбайн аюулгүй байдлыг хангуулж, стандартыг мөрдүүлнэ.

2.1.2.4.Ерөнхий боловсролын сургууль, сургуулийн өмнөх боловсролын байгууллагуудын камерын шинэчлэлийг хийнэ.

2.1.2.5.“Гэрт ойр цэцэрлэг, сургууль-хамгийн сайн цэцэрлэг, сургууль” арга хэмжээг хэрэгжүүлнэ.

2.1.3.Боловсролын бүх шатанд хүүхдийн хөгжил, хамгааллын орчныг сайжруулж, хүүхдийн сурч, хөгжих тэгш эрхийг хангана.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

2.1.3.1. Бага насны (0-5 нас) хүүхдийн цогц хөгжлийг дэмжих арга хэмжээг хэрэгжүүлж, 1-2 насны хүүхдийн яслийн үйлчилгээний хувилбарыг дэмжиж ажиллана.

2.1.3.2. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг сурч, хөгжихөд шаардлагатай тохируулгат хэрэглэгдэхүүнээр хангах, багшлах боловсон хүчнийг мэргэшүүлэхэд дэмжлэг үзүүлж, хамтран ажиллана.

2.1.3.3. Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын үйлчилгээнд хамрагдаж чадахгүй байгаа ялгаатай хэрэгцээтэй хүүхдийг гэр бүл, орон нутгийн онцлог байдалд нийцүүлэн, хувилбарт сургалтад хамруулна.

2.1.3.4. Суралцагсдын дундах үе тэнгийн дээрэлхэлт, хорт зуршлаас урьдчилан сэргийлэх, сургалтын байгууллагын орчинд цахим эрсдэлээс хамгаалах, дотуур байрын хүүхдийн амьдрах эрүүл, аюулгүй орчин нөхцөлийг сайжруулж, төр, хувийн хэвшлийн байгууллагуудад "Хүүхэд хамгааллын бодлого" хэрэгжүүлнэ.

2.1.3.5. Сургууль, цэцэрлэгийн гал тогооны эрүүл ахуйг стандартын шаардлагад нийцүүлэх, үдийн хоол, цайнд тавих дотоод хяналтыг сайжруулна.

2.1.4. Багш, удирдах ажилтны ёс зүй, мэргэжил, ур чадварыг дээшлүүлж, боловсон хүчний нөөцийг нэмэгдүүлнэ.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

2.1.4.1. "Багш хөгжлийн танхим"-ын тохижилт, засварт дэмжлэг үзүүлнэ.

2.1.4.2. Элсэлтийн ерөнхий шалгалтад 800 оноо авсан сурагч, бэлтгэсэн багшид хүндэтгэл үзүүлж, урамшуулна.

2.1.4.3. Ерөнхий боловсролын сургуульд ажиллах хоол зүйч, сэтгэл зүйчийг бодлогоор бэлтгэн, тогтвортой ажиллахад дэмжлэг үзүүлнэ.

2.1.4.4. Багшийн ёс зүйг эрхэмлэн сахих, багшийн үнэлэмжийг нэмэгдүүлэх, байгууллагын соёлыг төлөвшүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

2.1.5. Иргэдийн насан туршдаа тасралтгүй суралцахуйг дэмжин, сургалтын орчин нөхцөлийг бүрдүүлнэ.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

2.1.5.1. Насан туршийн боловсролын үндсэн чиглэлийг хөгжүүлж, иргэдийн амьдралын чанарыг дээшлүүлэх бодлого хэрэгжүүлнэ.

2.1.5.2. Иргэдийн орон зайнаас үл хамааран суралцах боломжийг нэмэгдүүлнэ.

2.1.5.3. Сургалт нөлөөллийн үйл ажиллагааг хэрэгжүүлсэн, суралцагч баг, хамт олныг дэмжиж, урамшуулна.

2.1.5.4. Эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, гэр бүл иргэдэд чиглэсэн сургалт, нөлөөллийн үйл ажиллагааг цахим, танхим хосолсон хэлбэрээр зохион байгуулна.

2.2. ЭРҮҮЛ МЭНД

Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулж, нийт хүн амд эзлэх эрүүл дадал хэвшилтэй, идэвхтэй амьдралын хэв маягтай иргэдийн эзлэх хувийг нэмэгдүүлнэ.

2.2.1. Эрүүл амьдралын хэв маяг, урьдчилан сэргийлэлт, эрт илрүүлгийг дэмжсэн санхүүжилт, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

2.2.1.1. Иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх сургалт сурталчилгааг зохион байгуулна.

2.2.1.2.Халдварт, халдварт бус өвчнөөс сэргийлэх "Эрүүл Монгол" хөтөлбөрийг салбар дундын оролцоотойгоор хувь хүн, гэр бүл, байгууллага, аж ахуйн нэгжийн хүрээнд хэрэгжүүлнэ.

2.2.1.3."Эрт илрүүлэг 2" арга хэмжээний хүрээг зорилтот бүлэгт чиглүүлж, эмчилгээ, хяналт, урьдчилан сэргийлэлтийн арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

2.2.1.4.Эрчүүдийн эрүүл мэндийг дэмжих арга хэмжээг мэргэжлийн байгууллагуудтай хамтран хэрэгжүүлж, Бүсийн оношлогоо эмчилгээний төвд кабинет тохижуулан, андорлогийн мэргэжлийн эмчтэй хамтарч ажиллана.

2.2.2.Өрхийн Эрүүл мэндийн төвүүдийн чадавхыг дээшлүүлж, үзүүлэх тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэн иргэдийн санхүүгийн болон цаг хугацааны хүлээгдэл чирэгдлийг бууруулна.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

2.2.2.1.Уламжлалт, сэргээн засах тусламж үйлчилгээг орчин үеийн анагаах ухаантай хослуулан хөгжүүлж, уламжлалт эмийн хэрэглээг нэмэгдүүлнэ.

2.2.2.2.Үндэсний эрүүл мэндийн мэдээллийн нэгдсэн санд орох мэдээллийг олон улсын стандартын дагуу цуглуулж, түүний аюулгүй байдлыг хангах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

2.2.3.Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн хангалт, нийгмийн баталгааг сайжруулж, эрүүл мэндийн ажилтны чадамжид суурилсан бүтээмжийг тасралтгүй дээшлүүлнэ.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

2.2.3.1.Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн хангалт, хөгжил, нийгмийн баталгааг сайжруулах аймгийн хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

2.2.3.2.Орон нутагт эрүүл мэндийн мэргэжилтэн бэлтгэхэд дэмжлэг үзүүлж, хамтран ажиллана.

2.3.ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУД, ГЭР БҮЛИЙН ХӨГЖИЛ, ХАМГААЛАЛ

Хүүхэд, гэр бүл, залуучуудын хөгжил, хамгааллын үйл ажиллагааг оновчтой зохион байгуулан гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эрхийн зөрчлийг бууруулж, бие болоод сэтгэлзүйн хувьд эрүүл хүүхдийг төлөвшүүлэн, эх оронч үзэлтэй, иргэний үүрэг хариуцлагаа ухамсарласан, нийгмийн идэвхтэй шинэ үеийн залуучуудыг бэлтгэнэ.

2.3.1.Гэр бүлд ээлтэй, тэгш хүртээмжтэй цогц арга хэмжээг хэрэгжүүлнэ.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

2.3.1.1.Гэр бүлийн үнэ цэнэ, эцэг эхийн үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх, гэр бүлийн хүчирхийллийг бууруулах зорилгоор "Халуун ам бүл" төслийг хэрэгжүүлнэ.

2.3.1.2.Эрүүл нийгмийг бүтээхэд эрчүүдийн оролцоог нэмэгдүүлэх олон талт арга хэмжээг хэрэгжүүлнэ.

2.3.2.Хүүхдийг болзошгүй эрсдэл, хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хөгжүүлэх бодлогыг салбар дундын хамтын ажиллагаатай хэрэгжүүлж, хүүхэд хамгааллыг сайжруулна.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

2.3.2.1. “Хайрлагдсан хүүхэд” төслийг хэрэгжүүлж, хүүхэд хамгааллын үйл ажиллагааг сайжруулна.

2.3.2.2. Хүүхэд, өсвөр үеийнхнийг осол гэмтэлд өртөх, хорт зуршилд автахаас урьдчилан сэргийлэх, цахим орчны зохистой хэрэглээг бий болгох зорилгоор нөлөөллийн үйл ажиллагааг зохион байгуулна.

2.3.2.3. “Гэр бүлийн зуслан” төсөл хэрэгжүүлэх хувийн хэвшлийг дэмжин, хамтарч ажиллана.

2.3.2.4. Нийгмийн ажилтнуудыг чадавхжуулах, ажиллах нөхцөлийг сайжруулах арга хэмжээг хэрэгжүүлнэ.

2.3.3. Залуучуудын бүх талын хөгжилд дэмжлэг үзүүлж, олон нийтийн үйл ажиллагаанд оролцох оролцоог нэмэгдүүлнэ.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

2.3.3.1. Залуучуудад гэр бүл төлөвлөлт, гэр бүлийн тогтвортой байдлыг нэмэгдүүлэхэд чиглэсэн “Аз жаргалтай гэр бүл” сургалтын хөтөлбөрийг нэвтрүүлж, залуучуудын хамрагдалтыг нэмэгдүүлнэ.

2.3.3.2. Зорилтот бүлгийн залуучуудыг хөгжлийн үйлчилгээнд хамруулах, “Залуусын боломж” явуулын үйлчилгээг хэрэгжүүлнэ.

2.3.3.3. Төрийн бүх шатны байгууллагад залуу албан хаагчдыг сургах, дадлагажуулах, ур чадварыг дээшлүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

2.3.3.4. Төр, иргэний нийгмийн болон зорилтот бүлгийн иргэд рүү чиглэсэн сайн дурын ажил, санал санаачилгыг бүх талаар дэмжинэ.

2.4. ҮНДЭСНИЙ БАХАРХАЛ, ӨВ СОЁЛ

Үндэсний өв соёлоо хамгаалсан, эх, оронч үзэлтэй иргэнийг төлөвшүүлж, соёл, урлагийн үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлж, соёлын дархлааг бэхжүүлнэ.

2.4.1. Соёлын өвийн хадгалалт хамгаалалтыг сайжруулна.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

2.4.1.1. Соёлын биет болон биет бус өвийг судлан шинжлэх, түгээн дэлгэрүүлэх, өвлүүлэн уламжлуулах, хамгаалах бодлогыг хэрэгжүүлнэ.

2.4.1.2. Баяннамсрай, Арвайн хүрээ цэцэрлэгт хүрээлэнгүүдийг шашин, соёлын өв агуулгаар тохижуулна.

2.4.1.3. Археологийн олдворуудыг түшиглэн иргэдэд түүх, соёлыг сурталчлах ажлыг зохион байгуулна.

2.4.1.4. Үндэсний өв соёлыг түгээн дэлгэрүүлэх, сурталчлах ажлыг олон талт хэлбэрээр зохион байгуулна.

2.4.2. Бүх нийтийн соёлын боловсролыг олгох үйл ажиллагааг орон нутгийн онцлогт тохируулан шинэлэг арга хэлбэр ашиглан хөгжүүлнэ.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

2.4.2.1. “Бүх нийтийн соёлын боловсрол” арга хэмжээг хэрэгжүүлж, иргэдийг соён гэгээрүүлэх ажлыг мэргэжлийн байгууллага, холбоодтой хамтран зохион байгуулна.

2.4.2.2. Номын сангийн цахим үйлчилгээг сурталчлах, түгээн дэлгэрүүлэх арга хэмжээг зохион байгуулна.

2.4.2.3. Арвайхээр хот үүсэн байгуулагдсаны түүхт 300 жилийн ойг угтан өв соёл, түүхэн хөгжлийн баримтат киног бүтээж, нийтийн хүртээл болгоно.

2.5. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ, НИЙГМИЙН ХАМГААЛАЛ

Ажлын байр бий болгож, нийгмийн хамгаалал, хөгжлийн үйлчилгээг зорилтот бүлгүүдэд оновчтой хүргэж, хөдөлмөр эрхлэх боломжтой хүн бүрийг ажлын байртай болгох бодлогыг баримтална.

2.5.1. Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэн салбар хоорондын хамтын ажиллагаа, бодлогын уялдааг хангах замаар ажлын байр бий болгоно.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

2.5.1.1. Бүс нутгийн хөгжил, орон нутгийн бүтээн байгуулалт, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл хөтөлбөр, хөнгөлөлттэй зээлд хамруулах замаар ажлын байрыг нэмэгдүүлнэ.

2.5.1.2. Хөдөлмөр зуучлалын үйлчилгээг дэмжин, цагийн ажлын тогтолцоог бий болгох санал санаачилгыг дэмжин хамтарч ажиллана.

2.5.1.3. Гарааны бизнес, шинэлэг санал санаачилгыг дэмжин тогтвортой ажлын байрыг нэмэгдүүлэхэд бодлогын дэмжлэг үзүүлнэ.

2.5.2. Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтэд нийцүүлэн ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйлчилгээнд иргэдийг хамруулна.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

2.5.2.1. Ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох үйлчилгээг ганцаарчилсан болон бүлгийн зөвлөгөө мэдээлэл өгөх хэлбэрээр зохион байгуулна.

2.5.2.2. Политехник коллежийн төгсөгчдийг орон нутгийн хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд тулгуурлан ажлын байранд зуучилна.

2.5.3. Хөдөлмөр нийгмийн гурван талт оролцоонд тулгуурлан хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, цалин хөлс, хөдөлмөрийн бүтээмжийг нэмэгдүүлнэ.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

2.5.3.1. Хөдөлмөр нийгмийн гурван талт хамтын хэлэлцээр, хөдөлмөрийн маргаан таслах комиссын үйл ажиллагааг өргөжүүлэх, хөдөлмөрлөх эрхийн маргааныг шийдвэрлэнэ.

2.5.3.2. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөл, Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх орон тооны бус байнгын комиссын гишүүдийг чадавхжуулна.

2.5.4. Нийгмийн халамжийн үйлчилгээг зорилтот бүлгийн өрх, иргэнд чиглүүлнэ.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

2.5.4.1. Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээг зорилтот бүлгийн өрх, иргэнд хүргэх ажлыг төрийн бус байгууллагатай хамтран хэрэгжүүлнэ.

2.5.4.2. Хууль тогтоомжид заасан нөхцөл, шаардлага хангасан зорилтот бүлгийн иргэдэд хүнс тэжээлийн дэмжлэгт үйлчилгээ үзүүлнэ.

2.5.4.3. Төр, төрийн бус байгууллагын түншлэл дээр тулгуурлан ахмад настны өдрийн асрамжийн үйлчилгээг хөгжүүлнэ.

2.5.4.4. Ахмадын тэтгэвэрт бэлтгэх хөтөлбөрт арга хэмжээг хэрэгжүүлэн, ахмадын хөдөлмөр эрхлэлт, идэвхтэй амьдралын хэв маягийг дэижиж, хамтран ажиллана.

2.5.5. Хөгжлийн бэрхшээлийн талаарх зөв ойлголт эерэг хандлагыг төлөвшүүлж, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн оролцоог нэмэгдүүлнэ.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

2.5.5.1. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрэлт хэрэгцээнд тулгуурлан сургалт, арга хэмжээнд зорилтот бүлгийн иргэдийг хамруулж, хөгжих, оролцох боломжийг нэмэгдүүлнэ.

2.5.5.2. Барилга байгууламж, орон сууц, нийтийн эзэмшлийн зам талбай, нийтийн тээвэр, мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлж, стандартыг мөрдүүлнэ.

2.5.5.3. Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг биеийн тамир, спорт, соёлын арга хэмжээнд оролцоход дэмжиж, салбар дундын уялдааг сайжруулан, төр, хувийн хэвшлийн байгууллагуудтай хамтарч ажиллана.

2.6. БИЕИЙН ТАМИР, СПОРТ

Биеийн тамир, спортыг хүн амын амьдралын хэв маяг, амьдралын чанарыг дээшлүүлэх хэрэглүүр болгож, идэвхтэй хөдөлгөөн, спортоор хичээллэх орчин нөхцөлийг сайжруулан, тив, дэлхий, олимпод оролцох тамирчдад дэмжлэг үзүүлнэ.

2.6.1. Хүн амыг идэвхтэй хөдөлгөөнөөр хичээллэж, эрүүл мэндээ дэмжихэд чиглэсэн орчин нөхцөл, боломжоор хангаж, нийтийн биеийн тамирын үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

2.6.1.1. Иргэдийг эрүүл чийрэг, бүтээлч зан чанарыг эрхэмлэсэн өдөр тутмын дасгал хөдөлгөөн, зөв хооллолт, эрүүл амьдралын хэв маяг бүхий дадалд сургах, шинэ санал санаачилгыг дэмжин хамтран ажиллана.

2.6.1.2. Бүх нийтийн биеийн тамирын арга хэмжээнд оролцогчдын тоог нэмэгдүүлнэ.

2.6.2. Хүн амын бие бялдрын хөгжлийг хянах цахим өгөгдлийн санд биеийн тамир, спортын салбарын статистик мэдээллийн баазын мэдээлэлд баяжилт хийнэ.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

2.6.2.1. Иргэдийн бие бялдрын түвшин тогтоох сорилыг заавал биелүүлэх норм, нормативын дагуу насны ангиллаар жил бүр авч, цахим мэдээллийн санд баяжилт хийнэ.

2.6.3. Хүүхэд, залуучуудын спортын авьяасыг нээн илрүүлж, шилдэг тамирчдын залгамж халааг бэлтгэх, стандартад нийцсэн заал, талбай, дэд бүтцийг нэмэгдүүлнэ.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

2.6.3.1. Арвайхээр хотын даргын нэрэмжит уралдаан тэмцээнүүдийг уламжлал болгон зохион байгуулж, олимпийн төрлөөр улс, тив дэлхийн тэмцээнд оролцож амжилт үзүүлсэн тамирчдыг урамшуулж, мэргэжлийн спорт клубүүдтэй хамтран ажиллана.

2.6.3.2. Арвайхээр хотын аварга шалгаруулах нийтийн бүжиг, шагайн харваа, Арвайхээр марсофон тэмцээнийг жил бүр зохион байгуулна.

2.6.3.3."Ирээдүйн аварга" үндэсний бөхийн өсвөрийн аварга шалгаруулах барилдааныг уламжлал болгон жил бүр зохион байгуулна.

ГУРАВ.ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО

3.1.ТӨСӨВ САНХҮҮ

Төсөв санхүүгийн үйл ажиллагааг технологийн дэвшлийг ашиглан үр ашигтай удирдан, орон нутгийн өмчит газруудын үр өгөөжийг нэмэгдүүлж, төсвийн сахилга хариуцлагыг сайжруулна.яя

3.1.1.Төсөв үр ашигтай, төлөвлөгдөж зарцуулагдсан, татварын орлого нэмэгдэж, санхүүгийн зах зээлд оролцогч иргэдийн тоо нэмэгдсэн байна.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

3.1.1.1.Иргэн, аж ахуйн нэгжийн үйлдвэрлэл, үйлчилгээг хөгжүүлж, өрсөлдөх чадварыг сайжруулах, ажлын байрыг нэмэгдүүлэх замаар татварын бааз суурийг өргөтгөн, татварын орлогын төлөвлөгөөг бүрэн биелүүлнэ.

3.1.1.2.Эрсдэлийн үнэлгээ, мэдээлэлд тулгуурлан төсвийн төвлөрүүлэлт, зарцуулалтад дотоод хяналт шалгалтыг хийж, эрсдэлийг бууруулна.

3.1.1.3.Харьяа төрийн байгууллагуудын төсвийн захирагч, нягтлан бодогч нарын хууль, эрх зүйн мэдлэг, санхүүгийн боловсрол, сахилга батыг дээшлүүлнэ.

3.1.2.Орон нутгийн өмчит газруудын засаглалын менежментийг сайжруулж, ашигт ажиллагааг нэмэгдүүлнэ.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

3.1.2.1.Орон нутгийн өмчит газруудын үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж, дүгнэлт гарган, цаашид авах арга хэмжээний саналыг боловсруулж, холбогдох дээд шатны байгууллагад хүргүүлж, шаардлагатай арга хэмжээг хэрэгжүүлнэ.

3.1.2.2.Төрийн болон орон нутгийн өмчийн ашиглалт, хамгаалалтыг сайжруулж, төсвийн хөрөнгийг үр ашигтай зарцуулж, тэдгээрийн бүртгэл мэдээлэл, үнэлгээ, тайланг ил тод, нээлттэй болгон, өмч эзэмшигчдийн хариуцлагыг дээшлүүлнэ.

3.1.3.Улсын болон орон нутгийн төсөв, төсөл хөтөлбөрөөр хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажлын гүйцэтгэл, чанарыг сайжруулна.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

3.1.3.1.Өмнөх гэрээний үүргээ бүрэн биелүүлээгүй аж ахуйн нэгжийг тендерт оролцсон тохиолдолд тендерээс татгалзах үндэслэл болгоно.

3.1.3.2.Тендерт оролцсон аж ахуйн нэгж гэрээний үүргээ чанаргүй гүйцэтгэсэн тохиолдолд тендерт оролцох эрхийг хязгаарлуулна.

3.1.3.3.Тендерт оролцож шалгарсан аж ахуйн нэгж, байгууллага нь гэрээний үүргээ бусдад шилжүүлэхийг хориглох талаар гэрээнд тусгаж, хэрэгжилтэд хяналт тавина.

3.1.4.Төрийн худалдан авах ажиллагаанд технологийн дэвшлийг нэвтрүүлэх замаар хүний оролцоог бууруулж, мэдээллийн ил тод байдлыг нэмэгдүүлнэ.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

3.1.4.1.Төрийн худалдан авах ажиллагааны мэдээллийг цахим системээр дамжуулан олон нийтэд хүргэх хүртээмжийг нэмэгдүүлнэ.

3.1.4.2. Бүх шатны худалдан авах ажиллагаанд болон түүний гүйцэтгэлийн явцад хяналт, шалгалтыг тогтмол явуулж, эдийн засаг, нийгмийн статистик эмхэтгэлийг жил болгон гарган, иргэд, олон нийтийг мэдээллээр хангана.

3.2. ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ

Мал аж ахуйн үйлдвэрлэлийг тооноос чанарт шилжүүлж, мал аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангаж, газар тариалангийн бүтээгдэхүүний дотоодын үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ.

3.2.1. Мал сүргийг эдийн засгийн эргэлтэд оруулна.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

3.2.1.1. Малын үүлдэр угсааг сайжруулах замаар тооноос чанарт шилжүүлж, эдийн засгийн эргэлтэд оруулах бодлого баримтална.

3.2.1.2. Мал үржүүлэг, технологийн ажил, үйлчилгээний нэгжүүдтэй хамтран цөм сүргийн болон хээлтүүлэгч малыг ялган тэмдэглэж, бүртгэлжүүлэн, мал сүргийг даатгалд хамруулах ажлыг зохион байгуулна.

3.2.1.3. Махны чиглэлийн үхэр болон туслах аж ахуйг хөгжүүлж, хүнсний хангамжийг нэмэгдүүлнэ.

3.2.1.4. Малын тоо толгойн албан татварыг бүрэн төвлөрүүлнэ.

3.2.1.5. Залуу малчдыг дэмжих бодлогыг хэрэгжүүлж, малчдыг чадавхжуулна.

3.2.2. Бэлчээр ашиглалт, малын тэжээл үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

3.2.2.1. Малын тэжээл үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, өвс, тэжээлийн аюулгүйн нөөцийг бүрдүүлнэ.

3.2.2.2. Хамгаалагдсан хөрсний тариалалтыг нэмэгдүүлж, хөдөө аж ахуйн зохистой дадлыг хэвшүүлнэ.

3.2.3. Малчдын хоршоог чадавхжуулна.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

3.2.3.1. "Шинэ хоршоо хөдөлгөөн"-ийг үргэлжлүүлэн хоршоодыг чадавхжуулах замаар малчдын болон газар тариалангийн чиглэлээр дундын хоршоо байгуулахад мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлнэ.

3.2.3.2. Хоршоодыг чадавхжуулах сургагч багш нарыг бэлтгэж, зөвлөн туслах үйлчилгээ үзүүлнэ.

3.2.4. Мал эмнэлгийн оношилгоо, шинжилгээний түвшинг нэмэгдүүлж, мал, амьтны гоц халдварт, халдварт, өвчнөөс урьдчилан сэргийлэх, тэмцэх, халдваргүй өвчний өвчлөлийг бууруулна.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

3.2.4.1. Орон нутгийн төсвийн зардлаар хийгддэг дотрын халдварт хордлого, цусан халдварт, дуут хавдар, энтеробактериоз, гахайн цусан халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, дархлаажуулалтын төлөвлөгөөнд тусгагдсан малыг бүрэн хамруулна.

3.2.4.2. Үхэр сүргийг бруцеллёзын халдваргүй болохыг баталгаажуулж, мал эмнэлгийн үйлчилгээний нэгжүүд лабораторийн анхан шатны шинжилгээ хийж, хүнсний аюулгүй байдлыг хангана.

3.2.4.3. Мал эмнэлгийн салбарын боловсон хүчний мэргэжил, ур чадварыг дээшлүүлж, тусламж үйлчилгээ үзүүлэх техник, тоног төхөөрөмжийг сайжруулахад дэмжлэг үзүүлж, хамтран ажиллана.

3.2.5. Сумын хүн амын хэрэгцээт хүнсний ногоог 35 хувь, төмсийг 70 хувь дотоодын үйлдвэрлэлээр хангана.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

3.2.5.1. Тариаланчдыг үр, хөнгөлөлттэй зээлийн дэмжлэгт хамруулж, таримлын шинэ сорт нутагшуулах замаар ашигт таримлын нэр төрлийн нэмэгдүүлнэ.

3.2.5.2. Дайргын голын услалтын системийг сэргээн засварлаж, хөв цөөрөм байгуулах зураг төслийг боловсруулан, цахилгаан эрчим хүчний эх үүсвэрийг нэмэгдүүлнэ.

3.2.5.3. Өвөл, зуны хүлэмжийн аж ахуйг хөгжүүлж, нарийн ногооны үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ.

3.2.5.4. Төмс, хүнсний ногооны борлуулалтын сүлжээ бий болгохыг бодлогоор дэмжинэ.

3.2.5.5. Агро ойжуулалт, жимс, жимсгэнийн тариалалтыг нэмэгдүүлэхэд тарьц, суулгацын дэмжлэг үзүүлнэ.

3.2.5.6. Техник, тоног төхөөрөмжийн түрээсийн аж ахуй байгуулах хувийн хэвшлийг дэмжин, механикжуулалтын хувийг нэмэгдүүлнэ.

3.3. ҮЙЛДВЭР, ХУДАЛДАА, ҮЙЛЧИЛГЭЭ

Үйлдвэр, үйлчилгээний салбарыг хөгжүүлэх бодлогыг төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлж, дотоодын үйлдвэрлэл болон экспортыг нэмэгдүүлнэ.

3.3.1. Үйлдвэр, үйлчилгээний салбарыг хөгжүүлж, эдийн засагт эзлэх хувийг нэмэгдүүлнэ.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

3.3.1.1. "Цагаан алт" үндэсний хөдөлгөөнийг өрнүүлж, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжинэ.

3.3.1.2. Мал, эмнэлгийн лабораторийн багаж оношлуурыг сайжруулж, малчдын гар дээрээс ил задгай худалдаалж байгаа мах, сүү, цагаан идээг лабораторийн анхан шатны шинжилгээнд хамруулж, төвлөрсөн цэгийн тохижилтыг хийнэ.

3.3.1.3. Дайвар бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэр, цехийн бүтээгдэхүүнийг сурталчлах, борлуулалтын сүлжээг өргөтгөхөд дэмжлэг үзүүлж, хамтран ажиллана.

3.3.1.4. "Хүнсний хангамж, аюулгүй байдал" үндэсний хөдөлгөөнийг эрчимжүүлж, гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний дотоодын үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, мах сүүний улирлын хамаарлыг бууруулна.

3.3.1.5. Үйлдвэрийн аргаар төхөөрч, бэлтгэсэн мах, махан бүтээгдэхүүний борлуулалтыг төрийн худалдан авалтаар дэмжих замаар махны үйлдвэр, мал төхөөрөх цехүүдийн үйл ажиллагааг дэмжинэ.

3.3.1.6. Хүн амын эрүүл мэндийг хамгаалах зорилгоор хүнсний зориулалтын бус савны хэрэглээг бууруулна.

3.4.НОГООН ХӨГЖИЛ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ

Байгаль, түүх, соёлын өвд түшиглэсэн аялал жуулчлалыг хөгжүүлэн эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлж, байгаль орчны тэнцвэрт байдлыг хадгалан хүн амын эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг сайжруулна.

3.4.1.Байгалийн баялгийг зүй зохистой ашиглах, хамгаалах нөхөн сэргээх замаар экосистемийн тэнцвэрт байдлыг хадгална.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

3.4.1.1.Гадаргын усыг хуримтлуулж, усан сан бүхий газрыг нөхөн сэргээх төсөл, арга хэмжээг хэрэгжүүлнэ.

3.4.1.2.Худаг, усан сангийн хүртээмжийг нэмэгдүүлж, ундны усны чанар, аюулгүй байдлыг ханган, төвийн шугамд холбох ажлыг үе шаттай хэрэгжүүлнэ.

3.4.1.3.Усны хэрэглээ ашиглалтын хэмнэлт, дахин ашиглалтыг дэмжинэ.

3.4.1.4.“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг эрчимжүүлж, ногоон байгууламжийг нэмэгдүүлнэ.

3.4.1.5.Иргэд олон нийт, өсвөр үеийнхэнд экологийн боловсрол олгоно.

3.4.2.Байгаль орчинд учруулах сөрөг нөлөөллийг бууруулж, эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг хангах, менежментийг хэрэгжүүлнэ.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

3.4.2.1.Нийтийн эзэмшлийн зам талбайн цэвэрлэгээ, үйлчилгээнд хүний хөдөлмөр хөнгөвчилсөн механикжсан техник, хэрэгсэл нэвтрүүлнэ.

3.4.2.2.Дэд бүтэц, бүтээн байгуулалтад байгальд ээлтэй, дэвшилтэт техник технологи нэвтрүүлж байгаа байгууллага, аж ахуйн нэгж, иргэнийг дэмжих, урамшуулах замаар агаар, орчны бохирдлыг бууруулна.

3.4.2.3.Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгах дадал хэвшлийг бий болгох, иргэн, аж ахуй нэгж байгууллагын үүрэг хариуцлагыг сайжруулах менежментийг хэрэгжүүлнэ.

3.4.2.4.Гэрийн тэжээвэр амьтан, цэвэр үүлдрийн нохой, муур тэжээх соёлыг төлөвшүүлэх, эзэнгүй нохой муурыг устгах ажлыг дэвшилтэт арга технологи ашиглан хийнэ.

3.4.3.Байгаль, түүх, соёлын өвд түшиглэсэн аялал жуулчлалыг хөгжүүлнэ.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

3.4.3.1.Өндөр гэгээн Занабазарын нэрэмжит цэцэрлэгт хүрээлэнг түшиглэсэн соёлын аялал жуулчлалын бүтээгдэхүүнийг бий болгоно.

3.4.3.2.Орон нутгийн онцлогт тохирсон эвент арга хэмжээг бий болгон, улирлын аялал жуулчлалыг хөгжүүлж, эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлнэ.

3.4.3.3. Өндөр гэгээн Занабазарын нэрэмжит цэцэрлэгт хүрээлэн, Хүүхэд залуучуудын паркийн гэрэлтүүлэг, хогийн сав, сандлыг засварлаж, шинэчилнэ.

3.5.БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТ

Хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, газар зохион байгуулалтын төлөвлөлтийн дагуу дэд бүтцийг нэмэгдүүлж, иргэдийн ая тухтай амьдрах орчин бүрдүүлнэ.

3.5.1. Агаарын бохирдлыг бууруулна.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

3.5.1.1. Эрчим хүчний хэмнэлттэй, байгальд ээлтэй, дулааны эх үүсвэрээ утаагүй аргаар шийдсэн амины болон нийтийн орон сууц барих иргэд, аж ахуйн нэгжийг дэмжиж, хамтран ажиллана.

3.5.1.2. Инженерийн шугам сүлжээг үе шаттайгаар өргөтгөнө.

3.5.1.3. Сэргээгдэх эрчим хүч, цахилгаан халаалт, дэвшилтэт технологи хэрэглэгч байгууллага, аж ахуйн нэгж, өрхийн тоог нэмэгдүүлнэ.

3.5.1.4. Хуучин орон сууц, гэр хорооллын дахин төлөвлөлт хийх, түрээсийн орон сууц барих хувийн хэвшлийн саналыг дэмжиж, хамтран ажиллана.

3.5.3. Ерөнхий төлөвлөлтийн дагуу дэд бүтцийг хөгжүүлж, орон нутагт ажиллаж, амьдрах тав тухтай орчныг бий болгоно.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

3.5.3.1. Шинэ суурьшлын бүсийн дэд бүтэц, хатуу хучилттай авто зам, явган болон унадаг дугуйн зам, тэмдэг, тэмдэглэгээ, гэрлэн дохио, гэрэлтүүлэг, камержуулалтыг шинэчлэх, нэмэгдүүлэх ажлыг үе шаттай хэрэгжүүлнэ.

3.5.3.2. Үерээс хамгаалах далан, суваг шуудууг цэвэрлэх, өргөтгөх, шинэчлэх ажлыг хийнэ.

3.5.3.3. Эрчим хүчний уналттай газруудад дэд станц, шугам сүлжээг өргөтгөнө.

3.5.3.4. Хүнс, барааны төв захыг цэгцлэх, төрөлжүүлэх ажлыг үе шаттай хэрэгжүүлнэ.

3.5.3.5. Сууц өмчлөгчдийн холбооны үйл ажиллагааг сайжруулж, байруудыг сууц өмчлөгчдийн холбоонд нэгтгэнэ.

3.5.3.6. Хотын дүрмийг шинэчлэн боловсруулж, Хотын соёл хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлнэ.

3.6. ГАЗРЫН ХАРИЛЦАА

Хүн амын амьдрах орчин сайжирч, эдийн засагт хэмнэлттэй, үр өгөөжтэй, зөв төлөвлөлттэй хотыг бий болгоно.

3.6.1. Хот төлөвлөлтийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлж, газрыг төлөвлөлтийн дагуу олгоно.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

3.6.1.1. Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө, хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлнэ.

3.6.1.2. Нийтийн орон сууцны зориулалттай газруудыг орон нутгийн хэрэгцээнд авч, иргэдийг хөнгөлөлттэй нөхцөлөөр орон сууцаар хангах төслийг хэрэгжүүлнэ.

3.6.1.3. Тарагт сумын нутагт олгосон малчны хорооллын 90 өрхийн газар өмчлөлийн асуудлыг Тарагт сумын төрийн байгууллагатай хамтран шийдвэрлэнэ.

3.6.1.4. Сумын нутаг дэвсгэрт байгаа газруудын нэрийн тодруулалт хийнэ.

3.6.1.5. Геодезийн байнгын цэг, тэмдэгт болох 15 полигнометрийн цэгийг сэргээж, шинэчилнэ.

3.6.1.6. Шинэчилсэн хаягийн зургийн дагуу хаягийн тэмдгийг хийнэ.

3.6.1.7. Сумын төвд байгаа түүх, соёлын дурсгалт газрыг хамгаалалтад авах, сурталчлан таниулах, чөлөөлөх ажлыг хийж хэрэгжүүлнэ.

ДӨРӨВ. ХҮНИЙ ЭРХИЙГ ДЭЭДЭЛСЭН ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО

4.1. ХҮНИЙ ЭРХИЙГ ХАНГАХ, ГЭМТ ХЭРЭГТЭЙ ТЭМЦЭХ, УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ БОДЛОГО ЗОХИЦУУЛАЛТ

Хуулийг хэрэгжүүлж, хүний эрхийг дээдлэн шударга ёсны засаглалыг бэхжүүлэх замаар гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэнэ.

4.1.1. Хүний эрхэд суурилсан хандлагыг удирдлага болгон, шударга байдлын түвшний үнэлгээг нэмэгдүүлнэ.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

4.1.1.1. Нутгийн захиргааны байгууллагын шийдвэр, үйл ажиллагаанд жендэр, хүний эрхийн мэдрэмжтэй хандах, хүний эрхийн зөрчил гаргахгүй байхад анхаарч ажиллана.

4.1.1.2. Эрх зүйн сургалт, сурталчилгаа, мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлж, нийтээр дагаж мөрдүүлэх захиргааны хэм хэмжээний шийдвэрт иргэд, иргэний нийгмийн байгууллагын санал, үнэлгээг авах замаар олон нийтийн оролцоо, хяналтыг нэмэгдүүлнэ.

4.1.1.3. Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх арга хэмжээг тасралтгүй хэрэгжүүлж, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх олон нийтийн хяналтыг нэмэгдүүлж, бүх нийтээр авлигатай тэмцэх, шударга бус зүйлийг үл тэвчих сэтгэлгээ, хандлагыг төлөвшүүлэх бодлогыг үе шаттай хэрэгжүүлнэ.

4.1.2. Жендэрт суурилсан хүчирхийллийг бууруулна.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

4.1.2.1. Эрхэлж буй ажил, салбарын онцлог, амьдарч буй байршил зэргээс хамаарсан эрсдэлээс урьдчилан сэргийлэх мэдээллийг цахим орчинд түгээж, жендэрт суурилсан хүчирхийллийн талаарх ойлголтыг иргэд, олон нийтэд хүргэнэ.

4.1.2.2. Нутгийн захиргааны байгууллагад жендэрийн тэнцвэртэй байдлыг хангах үзэл баримтлалыг нэвтрүүлж, иргэдэд жендэрийн мэдрэмжтэй төрийн үйлчилгээг хүргэнэ.

4.1.3. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд олон нийтийн оролцоонд тулгуурласан бодлого хэрэгжүүлнэ.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

4.1.3.1. Гэмт хэрэг үйлдэгдэх шалтгаан нөхцөлийн судалгаанд тулгуурласан урьдчилан сэргийлэх ажлыг үр дүнд хүрэхүйц байдлаар үе шаттай зохион байгуулна.

4.1.3.2. Гэр хорооллын гудамж, нийтийн эзэмшлийн талбай, улсын болон орон нутгийн чанартай замын хяналтыг сайжруулж, теле-камерын тоог нэмэгдүүлэх, хүчин чадлыг сайжруулах арга хэмжээг үе шаттай хэрэгжүүлнэ.

4.1.3.3. Хууль тогтоомж, нийтээр дагаж мөрдөх эрх зүйн акт, техникийн зохицуулалт, стандарт, тэдгээрийг үндэслэн төрийн эрх бүхий байгууллагаас төрийн хяналт шалгалтад дэмжлэг үзүүлж, хамтран ажиллана.

4.2. ТӨРИЙН БҮТЭЭМЖ-ЦАХИМ ЗАСАГЛАЛ

Дэвшилтэт технологид тулгуурлан төрийн бүтээмжийг нэмэгдүүлнэ.

4.2.1. Мэдээллийн технологийн ашиглалтыг нэмэгдүүлж, цахим шилжилтийг эрчимжүүлнэ.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

4.2.1.1. "Цахим жишиг аймаг" хөтөлбөрийн хүрээнд хийгдсэн "Go uvurkhangai" аппликэйшн, 9 системийн үйл ажиллагааг жигдрүүлж, хэрэглээнд нэвтрүүлнэ.

4.2.1.2. Төрийн үйлчилгээний шат дамжлагыг бууруулах, үйл ажиллагаа, үйлчилгээг хялбаршуулах, цахимжуулах ажлыг үргэлжлүүлнэ.

4.2.1.3. Байгууллагын мэдээллийн аюулгүй байдлыг хангаж, кибер аюулгүй байдалд эрсдэлийн үнэлгээ хийлгэж, зөрчлийг арилгуулна.

4.2.1.4. Бүх нийтэд цахим ур чадвар олгох сургалтыг төр, хувийн хэвшлийн байгууллагуудтай хамтран үе шаттай зохион байгуулна.

4.2.2. Төрийн болон орон нутгийн өмчит байгууллагуудын ил тод байдлын түвшин, мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлнэ.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

4.2.2.1. Мэдээлэл хариуцагчийн хуулиар хүлээсэн үүргийг хэрэгжүүлж, хуулиар хаалттай, хязгаарлалттай гэж тогтоосноос бусад мэдээллийг олон нийтэд нээлттэй, ил тод болгоно.

4.2.2.2. Төрийн байгууллага албан тушаалтанд хандаж иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдол, санал хүсэлтийн шийдвэрлэлтийн процессыг хялбаршуулж, албан тушаалтны ажлын үр дүнд оруулан тооцдог болно.

4.2.2.3. Төрийн байгууллагаас гарч буй шийдвэр, үйл ажиллагааг олон нийтэд хүртээмжтэй хүргэх ажлыг иргэний нийгмийн байгууллага, хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтран хэрэгжүүлнэ.

4.2.3. Байгууллагын үйл ажиллагааг хэвийн явуулах орчин нөхцөлийг бүрдүүлнэ.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

4.2.3.1. Нутгийн захиргааны байгууллагын үйл ажиллагааны зардлыг төсөвт батлагдсан хэмжээгээр зарцуулж, техник хэрэгслийг үе шаттайгаар шинэчилнэ.

4.2.4. Төрийн байгууллагаас гарч буй бодлого шийдвэрийн төлөвлөлт, хэрэгжилтийн үр дүнг дээшлүүлнэ.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

4.2.4.1. Төрийн болон орон нутгийн өмчит байгууллагын дотоод хяналт, шалгалтын нэгжийн үйл ажиллагааг тогтмолжуулж, үр дүнд суурилсан хяналт-шинжилгээ, үнэлгээг хэрэгжүүлнэ.

4.2.4.2. Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулахад хувийн хэвшил, иргэний оролцоот хяналтыг хэрэгжүүлнэ.

4.2.5. Уламжлалт харилцаатай хот, мужуудтай хамтын ажиллагааг үргэлжлүүлнэ.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

4.2.5.1. Эгч дүүгийн харилцаатай Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Хубэй мужийн Шяогань хот, Оросын Холбооны Улсын хамтын ажиллагаатай Красноярск хот, Алтайн хязгаар, Саха улс, Франц Улсын Аллиер муж, Мулан хот, Бүгд Найрамдах Солонгос Улсын найрамдалт харилцаатай хотууд, Өвөр Монголын Өөртөө Засах Орны эзний хошуутай тус тус хамтын ажиллагаагаа өргөжүүлнэ.

4.2.5.2. Албан хаагчдыг гадаад улс оронд сургах, дадлагажуулах, харилцан туршлага солилцох, гадаадаас нарийн мэргэжилтэй боловсон хүчнийг урьж, харилцан туршлага солилцох үйл ажиллагаа явуулна.

4.2.5.3. Хамтын ажиллагаатай хот мужуудтай хөдөө аж ахуй, хот байгуулалт, байгаль орчин, жижиг дунд үйлдвэрийн технологи нутагшуулах, чиглэлээр хамтарч ажиллана.

4.2.6. Олон улсын байгууллагуудтай эдийн засаг, нийгмийн ач холбогдол бүхий томоохон төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд хамтран ажиллаж, төслийн үр өгөөжийг дээшлүүлнэ.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

4.2.6.1. Өрхийн үйлдвэрлэл, гарааны, жижиг, дунд бизнес эрхлэгчдийг дэмжих чиглэлийн олон улсын төслүүдэд иргэд, төрийн бус байгууллагуудыг хамрагдахад дэмжлэг үзүүлнэ.

4.3. ОРОН НУТГИЙН ХҮНИЙ НӨӨЦИЙН БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТ

Чадахуйн зарчимд суурилсан ёс зүйтэй, мэргэшсэн, тогтвортой хүний нөөцийг бүрдүүлж, иргэдэд үзүүлэх төрийн үйлчилгээний үр нөлөөг нэмэгдүүлнэ.

4.3.1. Хүний нөөцийн бодлогыг чадахуйн зарчимд нийцүүлэн хэрэгжүүлнэ.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

4.3.1.1. Төрийн үйлчилгээний байгууллагын гүйцэтгэх албан тушаалын сул орон тоог олон нийтэд мэдээлж, нээлттэй сонгон шалгаруулалтыг зохион байгуулж хэвшүүлнэ.

4.3.1.2. Хүний нөөцийн бодлого хэрэгжүүлж, зөрчил үүсэх эрсдэлээс урьдчилан сэргийлнэ.

4.3.2. Төрийн албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангаж, төрийн албан хаагчдын мэдлэг мэргэшлийг дээшлүүлж, чадавхыг бэхжүүлнэ.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

4.3.2.1. "Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөр"-ийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.

4.3.2.2. Төрийн албаны хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх, төрийн албан хаагчдыг мэргэшүүлэх, хөгжүүлэх зорилгоор төрийн албанд 5-аас доошгүй жил үр бүтээлтэй ажиллаж, сүүлийн 3 жилд нь "маш сайн" үнэлэгдсэн төрийн албан хаагчийг мэдлэг, мэргэшлээ дээшлүүлэх сургалтад хамруулах, туршлага судлах арга хэмжээнд хамруулна.

4.3.2.3. Ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшингийн үнэлгээг бодитой үнэлж, "маш сайн" үнэлэгдсэн төрийн албан хаагчдад байгууллагын зүгээс сургалтын төлбөрийн хөнгөлөлт дэмжлэг үзүүлэн төрийн албаны сургалтын байгууллага болох Удирдлагын академийн мэргэшүүлэх багц сургалтад хамруулна.

4.3.2.4. Төрийн албан хаагчийн ажлын гүйцэтгэл, үр дүнг бодит болгож, ажлын хариуцлага, сахилгыг сайжруулна.

4.3.3. Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлийг бууруулна.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

4.3.3.1.Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомжийг мөрдөх, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

4.3.3.2.Ёс зүйн дэд хорлоо нь төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилтэй холбоотой гомдол, мэдээллийг хянан шийдвэрлэж, хууль тогтоомжийн дагуу хариуцлага тооцно.

4.3.3.3.Ёс зүйн дэд хорооны гишүүдийг чадавхжуулах, ёс зүйн дэд хорооны ажлын гүйцэтгэл, үр дүнг харгалзан тогтвортой ажиллах хөшүүрэг болох урамшууллыг олгоно.

4.4.ОРОН НУТГИЙН ХАМГААЛАЛТ

Орон нутгийн хамгаалалтын томилгоот нэгжийн бэлэн байдлыг хангаж, дайчилгааны төлөвлөгөөг шинэчлэн боловсруулж, хүүхэд залуучуудад цэрэг-эх оронч үзэл төлөвшүүлнэ.

4.4.1.Дайчилгааны төлөвлөлтийг шинэчилж, хүүхэд залуучуудад цэрэг-эх оронч үзлийг төлөвшүүлэх сургалт, арга хэмжээг зохион байгуулна.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

4.4.1.1.Дайчилгааны төлөвлөлтийг шинэчилж, дайчилгааны болон орон нутгийн хамгаалалтын томилгоот нэгжийн бэлэн байдлыг хангуулна.

4.4.1.2.Хүүхэд залуучуудад цэрэг-эх оронч үзлийг төлөвшүүлэх, сургалт нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулна.

4.4.1.3.Цэргийн шинэчилсэн тоо бүртгэл, ээлжит цэрэг татлагыг зохион байгуулж, зарлан дуудах мэдэгдэл авсан иргэдийг бүрэн хамруулна.

4.4.1.4.Иргэдэд гамшиг ослоос урьдчилан сэргийлэх, хамгаалах, гал түймэртэй тэмцэх мэдлэг олгох сургалт, дадлагыг мэргэжлийн байгууллагатай хамтран зохион байгуулна.

4.4.1.5.Төр, Улаан загалмайн хамтын ажиллагааны нэгдмэл байдлыг зохион байгуулж, төрийн хүмүүнлэгийн үйл ажиллагааг орон нутагт хэрэгжүүлнэ.

---oOo---